| 1.1.16 | **Арга хэмжээ-16** Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналт болон тендер шалгаруулалтын баримт бичгийг хууль, журам, жишиг баримт бичгийн дагуу боловсруулагдсан эсэхэд хяналт тавьж,мэргэшлийн зөвөлгөө өгөх | Үйл ажиллагааны зардлаар | 1.Хууль, журмын дагуу ХАА-г зохион байгуулсан байна. | 2024 онд 325 тендерийг Хууль, журмын дагуу зохион байгуулсан. | 2025 онд төлөвлөсөн ХАА-г хууль, журмын дагуу төлөвлөж, зохион байгуулж тайлагнасан байна. | 2025 оны Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Худалдан авах ажиллагааны төлөвлөлт болон тендер шалгаруулалтын баримт бичгийг хууль, журам, жишиг баримт бичгийн дагуу боловсруулагдсан эсэхэд хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтын хүрээнд зөрчил дутагдал илрээгүй. Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн нарыг мэргэшил арга зүйгээр хангаж, 4 удаагийн сургалтад хамруулж, цаашид гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудлын хүрээнд зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, хяналт тавин ажиллаж байна. | 70% 100% |
| 1.2 | **ЗОРИЛТ-2 Нутаг дэвсгэрийн хэмжээнд худалдан авах ажиллагааны талаар мэргэжил, арга зүйгээр талуудыг хангах,сургалт зохион байгуулах, цахим худалдан авах ажиллагааны талаар мэдээллийг орон нутгийн захиргааны байгууллагуудыг хангах, худалдан авах ажиллагаа дахь орон нутгийн иргэдийн оролцоог дэмжиж, бусад улсын туршлагыг нэвтрүүлэх, нэгдсэн удидлагаар хангах** | | | | | | |
| 1.2.1 | **Арга хэмжээ-1** Байгууллагын болон харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, сургалт зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | 1.Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байдал<br>2.Сургалт зохион байгуулах | 2024 онд Мэргэжил арга зүйгээр тухай бүр хангаж, 3 удаа сургалт зохион байгуулсан. | 2025 онд мэргэжил арга зүйгээр тухай бүр хангаж ажиллах Сургалтыг улирал бүр буюу жилд 4 удаа зохион байгуулах | Байгууллагын болон харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, 2025 оны хагас жилийн байдлаар дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:<br>• 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын дарга, нягтлан бодогч, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” болон дүрэм, журмын талаар сургалтыг А.Амарын танхимд 2 удаа зохион байгуулсан.Сургалтад нийт 202 албан хаагч нар хамрагдсан.<br>• 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр сургууль, цэцэрлэгийн нягтлан бодогч нарт Тендерийн баримт бичгийг хэрхэн боловсруулах талаар сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийт 26 байгууллагын нягтлан бодогч нар оролцсон. | 90% 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр “ХОЙД БҮС-ЭРДЭНЭТ 2025” эдийн засгийн форумд “Ногоон худалдан авалт, давуу эрх” сэдвээр иргэд болон орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагад зөвлөгөө мэдээллийг хүргэж ажилласан.<br>• 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Төрийн байгууллагуудын дарга, нягтлан бодогч, худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг ажилтан, албан хаагчдад “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, анхаарах асуудал” сэдвээр сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 53 байгууллагын 93 албан хаагч хамрагдсан.<br>Харьяа байгууллагуудын дарга, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүдэд тухай бүр заавар зөвлөгөө өгөн ажиллаж байна. | |
| 1.2.2 | **Арга хэмжээ-2**<br>Худалдан авах ажиллагааны А-3 шалгалтыг Төрийн Худалдан авах ажиллагааны газартай хамтран зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Сургалт зохион байгуулах | Шалгалтыг 6 удаа зохион байгуулсан. | Шалгалтыг 6 удаа зохион байгуулах | Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран 2025 оны 6 сарын байдлаар Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны А3 сертификатыг олгох шалгалтыг 8 удаа зохион байгуулан ажилласан. Тус шалгалтад нийт 344 иргэн орсоноос 39 иргэн тэнцэж А-3 сертификаттай болсон байна. | 100%<br>100% |
| 1.2.3 | **Арга хэмжээ-3**<br>Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулахад мэргэжил арга зүйн удирлагаар хангаж ажиллах, хяналт тавих | Үйл ажиллагааны зардлаар | 1.Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байдал<br>2.хяналтын тоо | 2024 онд 3 удаа сургалт нийт 13 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөөг утсаар болон биеэр өгсөн байна. 2024 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд 1 удаа хяналт тавьж, зөвлөмж хүргүүлсэн. | Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд 1 удаа хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар тухай бүр хангаж ажиллах | 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Аймгийн ЗДТГ-ийн Хууль эрх зүйн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын удирдлага болон холбогдох мэргэжилтэнүүд оролцсон хамтарсан уулзалт зохион байгуулж Аймгийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын талаарх мэдээлэл хийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас өмнө гэрээний тусгай нөхцөлд тусгах саналуудыг хяналт тавих байгууллагуудаас авч тулгамдсан асуудлуудыг хэлэлцсэн. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиглэлээр 4 удаа сургалт зохион байгуулсан. Тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилласан. Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөлтөд тухай бүр хяналт тавьж ажилласан. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд 2 | 70%<br>100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суманд 1 удаа газар дээр очиж хяналт тавьж ажилласан. | |
| 1.2.4 | **Арга хэмжээ-4**<br>Худалдааны авах ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг бэлтгэж Аймгийн удирдлага, захиргааны байгууллагуудыг мэдээллээр хангаж, ил тод байдлыг хариуцан ажиллах | Үйл ажиллагааны зардлаар | 1.Мэдээллийн ил тод байдал<br>2.Мэдээллээр хангасан байдал | 2024 оны Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг 100 хувь хангаж ажилласан. | Худалдан авах ажиллагааны мэдээллийг бэлтгэж танилцуулах, ил тод байдлыг хангаж ажиллах | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг Орхон аймагт 2025 оны 02 дугаар сарын 25-ний өдөр зохион байгуулагдсан. Хэлэлцүүлэг зохион байгуулахад оролцоо болон зохион байгуулалтыг хариуцан, "Хуулийн хэрэгжилт орон нутагт тулгамдсан асуудал" сэдвээр мэдээлэл хийсэн. Аймгийн ИТХ-ын хурлын зөвлөл 2025.06.02-ний өдөр хуралдсан. Уг хурлаар 2025 оны худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг хийсэн. Мөн 2025.05.28-ний өдөр иргэдийн хийсэн хэлэлцүүлэгт оролцож худалдан авах ажиллагааны талаар мэдээлэл хийлээ. Худалдааны авах ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг бэлтгэж Аймгийн удирдлага, захиргааны байгууллагууд, иргэдийг мэдээллээр тогтмол хангаж, ил тод байдлыг хариуцан ажиллаж байна. | 90%<br>100% |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2<br>Төрийн захиргааны Удирдлагын манлайллыг хангах, төрийн албан хаагчдын ажлын үр нөлөө, ур чадвар, чадавхийг бэхжүүлэх зарчмыг баримтлан, байгууллагын өмнө тавигдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх мэргэшсэн, чадварлаг баг бүрдүүлэх** | | | | | | | |
| 2.1 | **ЗОРИЛТ-1 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, газрын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах замаар захиргааны удирдлагын манлайллыг хангах** | | | | | | |
| 2.1.1 | **Арга хэмжээ-1**<br>Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, тайлагнах, дүгнүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтууд хангагдсан байна. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг стратегийн 2 зорилгыг хэрэгжүүлэх 3 зорилт 35 арга хэмжээтэйгээр боловсруулан Аймгийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан. 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 96.6 хувийн | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан байна. | Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг стратегийн 2 зорилгыг хэрэгжүүлэх 3 зорилт 35 арга хэмжээтэйгээр боловсруулан Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хянуулж, Аймгийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайланг нэгтгэн дүгнүүлэхээр ХШҮХ-т хугацаанд нь хүргүүлсэн. | 70%<br>100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гүйцэтгэлтэй байна. | | | |
| 2.1.2 | **Арга хэмжээ-2**<br>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн нийгэм эдийн засгийн зорилтод тусгагдсан эрхлэх асуудалд хамаарах заалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах, хяналт тавих, гүйцэтгэл үр дүнг тайлагнах | Үйл ажиллагааны зардлаар | Байгууллагын эрхлэх асуудалд хамаарах заалтыг хэрэгжилт хангагдсан байна. | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн нийгэм эдийн засгийн зорилтод тусгагдсан эрхлэх асуудалд хамаарах заалтуудын биелэлтийг сар бүр, хагас, бүтэн жилийн байдлаар гарган ХШҮ-ний хэлтэст хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | Худалдан авах ажиллагаатай холбоотой заалтыг хэрэгжүүлж, тайлагнасан байна. | Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт худалдан авах ажиллагаатай холбоотой заалт тусгагдаагүй боловч дараах 1 заалтыг хэрэгжүүлэх зорилт тавьсан. Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.1.4.5."Эрдэнэтэд үйлдвэрлэв" төвийн барилгыг ашиглалтад оруулж, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих уг заалтын хүрээнд тендерт оролцогч орон нутгийн ААНБ-уудад давуу эрх тооцон ажиллаж байна. Гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулагдсан 212 ажлын гүйцэтгэгчээр 221 ААНБ шалгарсан байна. Шалгарсан оролцогчдын 105 буюу 47.5 хувьд нь Орхон аймгийн орон нутгийн ААНБ шалгарсан байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн нийгэм эдийн засгийн зорилтод тусгагдсан эрхлэх асуудалд хамаарах заалтуудын биелэлтийг сар бүр, хагас, бүтэн жилийн байдлаар гарган ХШҮ-ний хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. Хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих зорилгоор байгууллагын Дотоод хяналт шалгалт зохион байгуулах 2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан. Байгууллагын эрхлэх асуудалд хамаарах заалтууд бүрэн хэрэгжсэн. | 70%<br>100% |
| 2.1.3 | **Арга хэмжээ-3**<br>Худалдан авах ажиллагааны газар болон эрх бүхий дээд байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэр эрх зүйн актын биелэлтийг цаг тухайд нь гаргаж биелэлтийг хангаж ажиллах | Үйл ажиллагааны зардлаар | Хууль, бодлогын баримт бичиг, эрх зүйн актуудын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Худалдан авах ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичгүүдийг хяналтанд авч хэрэгжилтийг хангаж биелэлтийг тухай бүр хугацаанд нь гаргаж өгсөн. | Бодлогын баримт бичгийг хяналтанд авч, хэрэгжүүлэн биелэлтийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна. | Худалдан авах ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичгүүдийг хяналтанд авч хэрэгжилтийг хангаж биелэлтийг тухай бүр хугацаанд нь гаргаж өгсөн. Үүнд:<br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн биелэлт 4 заалт,<br>- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн биелэлт 1 заалт<br>- ЗГ-ын тогтоол-10 заалт<br>- ЗГ-ын хуралдааны тэмдэглэл – 4 заалт<br>- ЗГ-ын албан даалгавар – 3 заалт | 70%<br>100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Сангийн сайдтай байгуулсан гэрээнд 8<br>-Шадар сайдтай байгуулсан гэрээнд 7<br>-ЗГХЭГ-тай байгуулсан гэрээнд 1 заалтуудыг хэрэгжүүлж, хугацаанд нь бүрэн тайлагнан ажилласан. | |
| 2.1.4 | **Арга хэмжээ-4**<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Дүрэм, журмын хэрэгжилт хангагдсан байна. | Байгууллагын ёс зүйн дэд хороог хуульд заасны дагуу 3 хүний бүрэлдхүүнтэйгээр байгуулсан. Албан хаагчдад иргэн, хуулийн этгээдээс ёс зүйн зөрчилтэй холбоотой аливаа гомдол санал ирээгүй байна. | Байгууллагын хэмжээнд мөрдүүлж ажиллах | Байгууллагын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг батлуулж төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг зохион байгуулсан.<br>✓ Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн танилцуулга сургалтыг 2 удаа<br>✓ Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтад байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулсан.<br>✓ 2025.05.22-ны өдөр шинээр томилогдсон Нягтлан бодогчид Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулсан.<br>Тайлант хугацаанд албан хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбоотой ямар нэг гомдол ирээгүй болно. | 100/.<br>100% |
| 2.1.5 | **Арга хэмжээ-5**<br>Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомж,стандартыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Хууль тогтоомжид нийцсэн байна. | ХААГ нь 2024 онд байгуулагдаж 2024-2027 он хүртэлх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг баталсан. Уг хөтөлбөр нь 5 бүлэг, 19 дэд бүлгээс бүрдсэн. Уг хөтөлбөрт Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаар хангаж, сургаж чадавхижуулах асуудлын тусган мөрдөн ажиллаж байна. | Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаар хангаж, сургаж чадавхижуулах ажлыг зохион байгуулах | Байгууллагад ахлах мэргэжилтэн, дотоод хяналт шалгалтын мэргэжилтэн гэсэн 2 сул орон тоо гарсан. Төрийн албаны салбар зөвлөлд захиалга өгч сул орон тоог хуулийн дагуу сэлгэн, шилжүүлэхээр зарласан. Ирсэн материалуудаас ажлын байрны сонгон шалгаруулалтыг хийж Ахлах мэргэжилтэн-1, Дотоод, хяналт шалгалтын мэргэжилтэн-1 томилсон. Дахин хуулийн мэргэжилтэн болон Худалдан авах ажиллагааны мэргэжилтний сул орон тоо гарсан. Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тоог зарлах хүсэлт хүргүүлсэн. Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хөдөлмөрийн харилцааг зохицуулж, албан хаагч нарын ажиллах ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, сургаж чадавхижуулах дараах ажлуудыг зохион байгууллаа.<br>Үүнд:<br>✓ Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын гэр бүлийг хамруулан “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт сургалт; | 90/.<br>100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд байгууллагын албан хаагчид болон тэдний гэр бүлийн дунд "Ухаалаг-хүүхэд Ухаалаг хэрэглээ" сэдэвт сургалтад хамруулсан.<br>✓ Хөдөлмөрийн дотоод журмын дагуу байгууллагын нийт албан хаагчдыг дархлаажуулалтын аяны хүрээнд албан хаагч тус бүрийг 80,000 төгрөгийн үнэ бүхий шаардлагатай амин дэмээр хангасан.<br>✓ Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтнийг surgalt.gov.mn дээрх 3-н сургалтад хамруулсан.<br>✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалт 2 удаа;<br>✓ Хувийн зохион байгуулалт ба цагийн менежментийн сургалт 1 удаа<br>Худалдан авах ажиллагааны хууль, журмын сургалтад байгууллагын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулан 1 удаа зохион байгуулан ажиллалаа. | |
| 2.1.6 | **Арга хэмжээ-6**<br>Албан тушаалын тодорхойлолтыг батлуулж мөрдүүлэх,Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, тайланг үнэлэх ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих | Үйл ажиллагааны зардлаар | Албан тушаалын тодорхойлолттой уялдсан, хууль тогтоомжийг хангуулсан байна. | Байгууллагын батлагдсан бүтэц орон тооны дагуу 10 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан батлуулсан. Төрийн захиргааны 6 албан хаагчтай гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний 3 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан хэрэгжилтэнд хяналт тавьж үнэлж дүгнэсэн. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хөдөлмөрийн гэрээг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг хянаж ажилласан байна. | Худалдан авах ажиллагааны газар 10 хүний бүтэц орон тоотой 2024.01.01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа эхэлсэн. Төрийн захиргааны-7, төрийн үйлчилгээний-3, 2025.06.05-ний өдрийн байдлаар 8 төрийн албан хаагч ажиллаж байна. 2 сул орон тоо гарсан. 2023 онд батлагдсан албан тушаалын тодорхойлолтын дагуу чиг үүргийг албан хаагч бүрээр мөрдүүлж байна. 2025 онд төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4, хөдөлмөрийн гэрээг 3 албан хаагчтай байгуулсан. Биелэлтийг дүгнэж, хяналт тавин ажиллаж байна. | 70%<br>100% |
| 2.1.7 | **Арга хэмжээ-7**<br>Байгууллагын албан хаагчдыг | Үйл ажиллагааны | Байгууллагын болон мэргэжилтнүүди | Байгууллагын албан хаагчдыг өдөр тутмын удирдлага, | Байгууллагын чиг үүрэгт хамаарах ажлыг бүрэн | Байгууллагын албан хаагчдыг өдөр тутмын удирдлага, зөвлөмж, арга зүйгээр хангаж, албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн | 90%<br>100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өдөр тутмын удирдлага, зөвлөмж, арга зүйгээр хангах, албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хяналт тавих, төрийн үйлчилгээг соёлтой шуурай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх | зардлаар | йн чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна. | зөвлөмж, арга зүй болон ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангаж ажилласан. Үүний үр дүнд 2024 онд мэргэжилтнүүдийн чиг үүрэг бүрэн хэрэгжүүлж ажилласан | хэрэгжүүлж ажилласан байна. | төлөвлөгөөгөөр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хяналт тавин, төрийн үйлчилгээг соёлтой шуурай хүргэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангаж ажилласан. | |
| 2.1.8 | **Арга хэмжээ-8** Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол санал хүсэлтийг судлан шийдвэрлэх ажлыг хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна. | 2024 онд иргэд, аж ахуйн нэгжээс байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын харилцаа хандлагатай холбоо асуудлаар ямар нэг гомдол, санал ирээгүй байна | Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн хүрээнд шийдвэрлэж ажиллах | Тайлант хугацаанд иргэд, аж ахуйн нэгжээс байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын харилцаа хандлагатай холбоо асуудлаар ямар нэг гомдол, санал ирээгүй байна. | 100/ 100% |
| 2.1.9 | **Арга хэмжээ-9** Байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүү, бусад нөөцийн талаар санал, төсвийн төсөл боловсруулж, батлуулах тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж тайлагнах, ил тод байдлыг хангах | Үйл ажиллагааны зардлаар | Төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн байна. | Байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд 2024 онд 700.9 сая төгрөгийн төсвийн Аймгийн ИТХ-аар батлуулсан. Нийт төсвийн 91,2 хувийг зарцуулж, албан газар хувь хүмүүст авлага өглөггүй ажилласан. Байгууллагын санхүүгийн мэдээллийг shilendans.gov .mn сайтад сар бүр ил тод мэдээллэсэн | Байгууллагын төсөв, санхүүг батлуулж, хууль журмын дагуу зарцуулж, тайлагнасан байна. | Байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд 2025 онд 607.9 сая төгрөгийн төсвийг Аймгийн ИТХ-аар батлуулсан. Батлагдсан төсвийг зардлын зүйл ангиар сар бүрийн зарцуулалтаар баталгаажуулан Санхүү төрийн сангийн төсвийн мэргэжилтэнд хүргүүлж сар бүрийн төсвийн хуваарийн дагуу санхүүжилтыг авч зарцуулалтыг тайлагнаж ажиллаж байна. Нийт төсвийн 28.4 хувийг зарцуулж, албан газар хувь хүмүүст авлага өглөггүй ажилласан. Байгууллагын санхүүгийн мэдээллийг shilendans.gov.mn сайт болон мэдээллийн самбараар сар бүр ил тод мэдээлж байна. | 100% 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.10 | **Арга хэмжээ-10**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшилтэд хяналт тавьж балансад байгаа өмч хөрөнгийг зохих журмын дагуу эзэмшиж, ашиглах | Үйл ажиллагааны зардлаар | Өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулан бүртгэлээр хяналт тавьсан байна. | 2024 онд нийт 362,957,915.75 төгрөгийн 101,591,796.41 төгрөгийн элэгдэлтэй 137 төрлийн 286 ширхэг үндсэн хөрөнгийг албан хаагч бүрээр эд хөрөнгийн ашиглалтын картыг хөтөлж, фото зургаар баталгаажуулж эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг хийж өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулан бүртгэлжүүлж хяналт тавин ажилласан. | Өмч хөрөнгийг эд хариуцагч нарт картаар эзэмшүүлж, жилд 2-с доошгүй удаа тайлан балансаар тулгаж, хөрөнгийн ашиглалтыг сайжруулж хяналт тавих, ТӨ, ТӨХ маягтуудыг данс бүрээр нэгтгэн үнэн зөв хөтлөх | 2025 онд байгууллагад нийт 336,377,595.75 төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд:<br>• Барилга 1 ширхэг 45,517,867.23 төгрөг<br>• Тээврийн хэрэгсэл 1 ширхэг 42,000,000 төгрөг<br>• Компьютер, дагалдах хэрэгсэл 58 нэр төрлийн 181,908,926.52 төгрөг<br>• Тавилга, эд хогшил 43 нэр төрлийн 65,300,802 төгрөг<br>• Биет бус хөрөнгө 1 ширхэг 1,650,000 төгрөг<br>Үндсэн хөрөнгийг албан хаагч бүрээр эд хөрөнгийн ашиглалтын картыг хөтөлж, фото зургаар баталгаажуулж эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг хийж өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулан бүртгэлжүүлж хяналт тавин ажилласан. | 90%<br>100% |
| 2.1.11 | **Арга хэмжээ-11**<br>Байгууллагын хэмжээнд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, тайлагналтад хяналт тавих | Үйл ажиллагааны зардлаар | Төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн байна. | - | Байгууллагын төсөв, санхүү, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэх | Шилэн дансанд байршуулах сар бүрийн болон улирлын санхүүгийн мэдээллийг үнэн зөв, иж бүрэн оруулж, шилэн дансны сайтад хуулийн хугацаанд илгээж, байгууллагын санхүүгийн мэдээллийг самбарт ил тод байршуулан ажилласан. 2025 оны хагас жилийн байдлаар санхүүгийн 171 мэдээлэл оруулахаас 68 мэдээллийг шилэн дансанд үнэн зөв оруулж, сайтад хугацаанд нь илгээсэн. | 50%<br>100% |
| 2.1.12 | **Арга хэмжээ-12**<br>Байгууллагын үйл ажиллагаанд дотоод Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тайлагнах, мэдээлэх | Үйл ажиллагааны зардлаар | Холбогдох журам, аргачлалын дагуу үнэн бодитой хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна. | - | Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Байгууллагын хэмжээнд 2025 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж батлуулан, мөрдөн ажиллаж байна. Байгууллагын 2025 оны хагас жилийн тайланд Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Баян-Өндөр, Жаргалант сумдад 2025 оны 03 дугаар сарын | 50%<br>100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 17-ноос 19-ний өдрүүдэд худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж байгаа эсэхэд явцын хяналт шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. | |
| 2.1.13 | **Арга хэмжээ-13** ХАСХОМ бүрдүүлэлт, мэдэгдэл тайлбар гаргах, урьдчилсан мэдүүлэг хянуулах үйл ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулж тайлагнах | Үйл ажиллагааны зардлаар | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль хэрэгжсэн байна. | 2024 онд ТЗ-8 зэрэглэлийн 1 ахлах мэргэжилтний 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг 2024.02.15-ний дотор www.meduuleg.iaac.mn сайтаар хүлээн авч хуулийн баталгаажуулсан. Үнэлгээний хорооны гишүүд болон худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 1744 хүний ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч АТГ-ын мэдүүлгийн www.meduuleg.iaac.mn системд бүртгэсэн байна. | Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна. | 2025 онд байгууллагын ТЗ-8 зэрэглэлийн 1 ахлах мэргэжилтэний 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг 2024.02.15-ний дотор www.meduuleg.iaac.mn сайтаар хүлээн авч хуулийн баталгаажуулсан. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар гараагүй байна. | 100% |
| 2.1.14 | **Арга хэмжээ-14** Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу стандартыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Стандарт хангасан байна. | 2024 онд байгууллагад 485 албан бичиг ирсэнийг тухай бүр хугацаанд нь шийдвэрлэн. Байгууллагаас явсан 96 албан бичгийг стандартын дагуу бүрдүүлж хүргүүлсэн. Байнга хадгалах 203ш, түр хадгалах 6ш | Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна. | 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар ирсэн бичиг 225, явуулсан бичиг 359, иргэдээс ирсэн өргөдөл гомдол байхгүй байна. Байгууллагад ирсэн албан бичгийг тухай бүр хугацаанд нь шийдвэрлэн ажилласан. Байгууллагаас явсан 359 албан бичгийг стандартын дагуу бүрдүүлж хүргүүлэн ажилласан. Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 онд байнга хадгалах 212ш хадгаламжийн нэгжийг цахимжуулж байгууллагын архивт хадгалж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хадгаламжийн нэгжийг цахимжуулж байгууллагын архивт хадгалсан. | | | |
| 2.1.15 | **Арга хэмжээ-15**<br>Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд биечлэн оролцох, өгөгдсөн үүрэг чиглэлийн биелэлтийг биечлэн хариуцан хангуулж хугацаанд нь хариу өгөх | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжүүлж ажилласан байна. | Аймгийн Засаг даргын 48 удаагын шуурхай хуралд зөвлөгөөнд биечлэн оролцож, өгөгдсөн үүрэг чиглэлийн биелэлтийг биечлэн хариуцан хангуулан ажиллаж хугацаанд нь хариу бүрэн өгч шийдвэрлэсэн. | Хуралд оролцох, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, тайлагнах | Аймгийн Засаг даргын 22 удаагын шуурхай хуралд зөвлөгөөнд биечлэн оролцож, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг биечлэн хариуцан хангуулан ажиллаж хугацаанд нь хариу бүрэн өгч шийдвэрлэсэн. Шуурхай хурлаас нийт манай байгууллагатай шууд болон шууд бус хамаарах 8 үүрэг даалгавар өгсөнийг бүрэн биелүүлж ажилласан. | 100%<br>100% |